



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/А09

Булган сум

Сумын Брэнд бүтээгдэхүүнийг батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Монгол Улсын Их хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны IY/23 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн Засаг даргын 2024-2028 оны “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ес дэх удаагийн сонгуулийн ээлжит XI хуралдааны XI/78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөрт тусгагдсан Үйлдвэрлэлийг хөгжүүлж, үйлчилгээг сайжруулан ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Орон нутгийн түүхий эдийн нөөц, газар зүйн онцлогт тулгуурласан сумдын онцлог “Брэнд бүтээгдэхүүн”-ийг хавсралтаар баталсугай.

2.Сумдын брэнд бүтээгдэхүүнүүдийг бодлогоор тасралтгүй хөгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг өгч ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Пүрэвсайхан), Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дарга (Д.Алтаншагай), мэргэжлийн холбоодод тус тус даалгасугай.

3.Сумдын “Брэнд бүтээгдэхүүн”-ийг батламжилж, урамшуулахыг Засаг даргын орлогч (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010982

Сүхбаатар аймгийн 2025 оны 10 сарын 30 өдөр бүр Doc/2025/Захирамж

Булган аймгийн Засаг даргын 2025 оны 10 сарын
30-ны өдрийн 3 дугаар захирамжийн хавсралт



Орон нутгийн түүхий эдийн нөөц, газар зүйн онцлогт тулгуурласан нутгийн
иргэдийн бахархал болсон онцлог "Брэнд бүтээгдэхүүн"-ий нэрс

№	Сумын нэр	Брэнд бүтээгдэхүүний нэр
1.	Баян-Агт	"Шимийн архи"
2.	Баяннуур	"Чацарганы тос"
3.	Бугат	"Гэрийн мод"
4.	Булган	"Сүү, сүүн бүтээгдэхүүн"
5.	Бүрэгхангай	"Чацарганы өтгөрүүлсэн шүүс"
6.	Гурванбулаг	"Хонины мах"
7.	Дашинчилэн	"Чацарганы шүүс"
8.	Могод	"Гүүний айраг"
9.	Орхон	"Эрүүл мэндийн цай"
10.	Рашаант	"Шимийн архи"
11.	Сайхан	"Гүүний айраг"
12.	Сэлэнгэ	"Бог будаа"
13.	Хангал	"Хангал өндөг", "Арвайн бүтээгдэхүүний багц"
14.	Хутаг-Өндөр	"Халтар арвайн гурил", "Төмс", "Зөгийн бал"
15.	Хишиг-Өндөр	"Хүүхдийн баривчны багц"
16.	Хялганат	"Зөгийн бал"
17.	Тэшиг	"Цөцгийн тос", "Масло", "Чипсэн ааруул"